



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014 . 03 . 05 № 1/337.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Чиглэл өгөх тухай**

Нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн зарим заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах чиглэлийг хүргүүлж байна.

1. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-д зааснаар тэжээгчийг нас барах үед түүний асрамжинд байсан, хуульд заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тухайлбал, эмэгтэй нь 55 нас, эрэгтэй нь 60 нас хүрсэн эхнэр, нөхөр тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Иймд тэжээгчийн нөхөр /эхнэр/ нь нас барах үед 60 /55/ настай хүрээгүй байсан нөхөр /эхнэр/ нь нөхөр /эхнэр/-өө нас барснаас хойш 60 /55/ нас хүрээд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох боломжгүй.

2. 55, 60 настай аав, ээждээ хөдөлмөрийн чадвартай хүү, охин нь өөрийн хүүхдээ үрчлүүлсэн бөгөөд үрчилсэн аав, ээж нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг тогтоож олгож болох эсэх тухайд:

Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2-д заасны дагуу 55, 60 ба түүнээс дээш настай байхдаа хүүхэд үрчилж авсан, улмаар хүүхэд үрчлэгч аав, ээж нь нас барсан тохиолдолд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзлыг хангаж байгаа бол тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоож болно.

3. Тэжээгч нь нас барахаас өмнө түүний асрамжинд байсан иргэн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгоогүй байгаад тэжээгчийг нас барснаас хойш “төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй” гэж тогтоогдсон тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох эсэх тухайд:

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т “тэжээгчийн асрамжинд байсан төрөлхийн тахир дутуу буюу 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү” тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрхтэй гэж зохицуулсан ба дээрх жишээнээс үзэхэд тэжээгчийг нас барснаас хойш тахир дутуу болсоныг тогтоосон тул тухайн иргэнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоохгүй.

Хэрэв Нийгмийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 304 дүгээр тогтоолоор баталсан “Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 4.1.4-д заасан зэрэг шалтгааны улмаас хөдөлмөрийн чадвар алдалт болон хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг нөхөн тогтоосон, энэхүү нөхөн тогтоосон огноо нь тэжээгчийн нас барахаас өмнөх хугацаанд хамаарч байвал тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох үндэслэлтэйг анхаарч, нягтлан шалгаж шийдвэрлэж байх нь зүйтэй.

ДАРГА  Ц.УРТНАСАН

My doc.Niigmiin daatgaliin bodlogiin heregiltin газар А-4

1000518